

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Г “Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам” Ү
батлах тухай

Хөрөнгийн зах зээлд арилжигдах үнэт цаасны нэгдсэн бүртгэлийн дугаар олгох ажлыг олон улсын стандартад нийцүүлэх, олон улсын үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагуудтай төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж байгаа болон зах зээлд арилжигдаж буй үнэт цаасны тухай мэдээллийг байнга солилцож хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг ТЭМДЭГЛЭН;

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСАНД НЭГДСЭН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд арилжигдах үнэт цаасанд нэгдсэн дугаар олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Олон Улсын Стандартын Байгууллага /цаашид “ОУСБ” гэх/-аас үнэт цаасыг дугаарлах ажиллагаанд мөрдөж буй стандартыг Монгол улсад нэгэн адил мөрдөнө.

1.3. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос үнэт цаасанд дугаар олгох эрхийг улсын хэмжээнд нэг байгууллагад олгох бөгөөд уг байгууллага нь энэ журмын 3.2.-т заасан шаардлагыг хангасан, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1 Дор дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1.1. “нэгдсэн дугаар” гэж Олон улсын стандартын байгууллага /цаашид “ОУСБ” гэх/-аас (International Standart Organization)-аас баталсан 6166:2001 тоот стандартад заасан бөгөөд Монгол Улсад хэрэглэх дугаарыг;

2.1.2. “нэгдсэн дугаар олгогч” гэж энэ журамд заасны дагуу Хорооноос эрх авсан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

2.1.3. “үнэт цаас” гэж Үнэт цаасны тухай хууль болон ОУСБ-гаас баталсан /ISO 6166:2001/ стандартад заасан хөрөнгийн зах зээлд арилжигдах санхүүгийн хэрэгслүүдийг;

2.1.4. “Үндэсний дугаар олгогч байгууллагуудын холбоо /цаашид “УДОБХ” гэх/” гэж ОУСБ-аас баталсан /ISO 6166:2001/ стандартыг олон улсад хэрэгжүүлэгч байгууллагыг.

Гурав. Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох

3.1. Нэгдсэн дугаар олгогч нь дараах эрх үүрэгтэй:

3.1.1. Хорооноос шийдвэрлэсний дагуу зохих үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох;

3.1.2. ОУСБ-аас тогтоосон стандартыг чанд мөрдөж уг стандартыг хэрэгжүүлэх талаар ажиллах;

3.1.3. Олгогдсон дугаарыг Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон тухайн үнэт цаас гаргагчид ажлын 2 хоногт багтаан мэдэгдэх;

3.1.4. Үнэт цаасны талаарх мэдээллийг холбогдох стандартад заасны дагуу УДОБХ болон бусад олон улсын холбогдох мэргэжлийн байгууллагуудад зөвшөөрөгдсөн хэмжээнд мэдээлэл өгөх, харилцан солилцох;

3.1.5. Нэгдсэн дугаар олгосон тайлан, холбогдох мэдээг сар бүр Хороонд хүргүүлж байх.

3.2. Нэгдсэн дугаар олгогч нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох бие даасан нэгжтэй байх;

3.2.2. Нэгдсэн дугаар олгох үйл ажиллагаа эрхлэх нэгжийн чиг үүргийг олон улсын стандартад нийцүүлэн, үйл ажиллагааныхаа журамд холбогдох зохицуулалтыг оруулсан байх;

3.2.3. Үнэт цаасны нэгдсэн дугаарын талаар олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцоход шаардлагатай боловсон хүчин, тоног төхөөрөмжтэй байна.

Дөрөв. Нэгдсэн дугаар

4.1. Үнэт цаасны нэгдсэн дугаарлалт нь ОУСБ-аас үнэт цаасыг дугаарлахтай холбогдуулан гаргасан стандарттай нийцсэн байна.

4.2 Үнэт цаасны бүртгэл, хадгаламж, шилжүүлэг, арилжаа, мэдээлэл солилцох үйл ажиллагаа нь тухайн үнэт цаас, олгогдсон нэгдсэн дугаарын дагуу хийгдэнэ.

4.3 Нэгдсэн дугаарт агуулагдах мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн танилцуулга болон бусад албан ёсны мэдээлэл байна.

4.4 Үнэт цаасны нэгдсэн дугаар нь дахин давтагдахгүй байх бөгөөд агуулагдах мэдээлэл нь зохих журмын дагуу дугаар олгох байгууллагад хадгалагдаж хамгаалагдана.

4.5. Хороо нь үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг гаргуулах, холбогдох стандартыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавина.